

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/66/СТА-ТӨҮГ

Агуулга

1 Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.13 Өвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10 Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Шилэн дансны мэдээлэл	8
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3 Менежментийн захидал	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	13
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайл.....	14
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5 Аудит хийсэн зорилтот түвшингийн биелэлт.....	17
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/440
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын захирал Ж.Солонго Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төрийн өмчийн хөрөнгийн түрээсийн орлогын 30 хувийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлэх, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай болох талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 12-ноос 2019 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Лайэн Аудит” ХХК-ийн аудитор Т.Бид-Ялав, П.Сайнцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь 2018 оны санхүүгийн тайлангаа захирлын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 18 тоот албан бичгээр “Лайэн аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоолоор тус тусдаа үйл ажиллагаа явуулж байсан Баримтат кино студи, Хүүхэд залуучуудын театр, Хүүхдийн кино студи, Монгол филм үзвэрийн газрыг нэгтгэж “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ыг байгуулсан. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Кино хальс боловсруулах
- Баримтат болон уран сайхны кино бүтээх
- Кино группэд шаардлагатай хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын удирдлага дараах хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрхзүйн актуудын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Соёлын тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Архивын тухай
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журмаас Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт орсноос бусад хууль, тогтоомж, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

“Монгол кино нэгтгэл” Төрийн өмчит үйлдвэрийн газар нь 2018 онд 23 ажиллагсадтай ажиллаж, 2018 оны нийт орлогын төлөвлөгөөг 97.0 хувиар биелүүлж, нийт зардлыг 7,673.1 мянган төгрөгөөр буюу 2 хувиар хэмнэж, 922,5 мянган төгрөгийн нийт ашигтай, 610.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. 2018 оныг 2017 онтой харьцуулахад өглөгийг 979.4 мянган төгрөгөөр, авлагыг 1,609.9 мянган төгрөгөөр тус тус бууруулсан боловч 2018 оны зорилтот түвшинг хангаж чадаагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь захирлын 42 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Excel” програм хангамж ашигладаг байна.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын

тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны нийт зардал 347.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1		
2	Төлбөрийн акт тогтоосон	1	3.2	
Дүн		2	3.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлснээс олсон орлогын 30 хувийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10. Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 онд үндсэн үйл ажиллагаанаас 268.6 сая, түрээсийн орлого 48.7 сая, хүүний орлого 3.1 сая, бусад орлого 27.8 сая нийт 348.2 сая төгрөгийн орлого олж үндсэн үйл ажиллагааны зардалд 339.3 сая, бусад зардалд 8.0 сая нийт 347.3 сая төгрөгийн зардал гаргаж 0.3 сая төгрөгийн орлогын албан татвар ногдуулж, 0.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn сайтад 2018 оны хагас жилийн санхүүгийн тайлан, 2019 оны зорилтот түвшингийн төсөл болон цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 237.3 сая төгрөгийн 13 ажил гүйлгээний мэдээллийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын

хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Програм хангамжийн талаар:

3.1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжгүй санхүүгийн тайланг эксел програм ашиглан бэлтгэж байна..

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Програм хангамжгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон програм хангамжтай болох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байгууллагын удирдлагад танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018.01.01	2018.12.31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	203,423,621.42	180,684,182.67
1.1.2	Дансны авлага	13,338,504.12	13,130,753.12
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,630,305.83	796,556.05
1.1.4	Бусад авлага	37,817,679.13	37,249,343.95
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	231,926,213.89	268,414,030.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10	Дуусаагүй үйлдвэрлэл		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	488,136,324.40	500,274,865.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	981,348,974.75	3,310,366,240.94
1.2.2	Биет бус хөрөнгө	345,580,118.40	768,978,372.80
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,326,929,093.15	4,079,344,613.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,815,065,417.54	4,579,619,479.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,281,321.57	1,948,692.12
2.1.1.2	Цалингийн өглөг	11,460.29	
2.1.1.3	Татварын өр	1,435,404.51	2,050,143.04
2.1.1.4	НДШ-ийн өглөг		

2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц / өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	250,000.00	
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,978,186.37	3,998,835.16
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	124,660,692.93	124,660,692.93
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,113,428,054.76	3,878,331,806.61
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	571,998,483.48	572,628,144.96
2.3.10			
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,810,087,231.17	4,575,620,644.50

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	236,859,091.55	268,609,706.36
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг /алдагдал/	236,859,091.55	268,609,706.36
4	Түрээсийн орлого	42,783,427.27	48,692,562.73
5	Хүүний орлого	4,907,267.11	3,116,281.25
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	7,815,027.77	27,807,229.09
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	283,527,433.40	339,329,031.70
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	8,152,321.00	7,997,820.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(6,827.80)	23,611.74
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	678,231.50	922,539.16
19	Орлогын татварын зардал	509,477.19	311,628.13
20	Татварын дараах ашиг (алдагдал)	168,754.31	610,911.04
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	168,754.31	610,911.04
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	168,754.31	610,911.04
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	124,660,692.93	767,847,936.36	943,452,491.72	-6,042,644.15	1,809,918,476.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		345,580,118.40	-943,452,491.72	597,872,373.32	
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	1,113,428,054.76		571,829,729.17	1,809,918,476.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				168,754.27	168,754.27
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	1,113,428,054.76		571,998,483.44	1,810,087,231.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				18,750.48	18,750.48
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	1,113,428,054.76		572,017,233.92	1,810,105,981.61
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				610,911.04	610,911.04
Өмчид гарсан өөрчлөлт		2,764,903,751.85			2,764,903,751.85
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.61		572,628,144.96	4,575,620,644.50

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	304,419,779.38	370,764,624.25
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	299,262,512.27	365,633,099.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		2,015,244.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтын орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	5,157,267.11	3,116,281.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	276,007,357.75	351,718,930.74
1.2.1	Ажиллагчдад төлсөн	116,771,233.00	127,199,823.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	30,651,000.00	36,064,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	33,956,828.50	55,974,801.41
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	45,093,310.25	85,529,352.02
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,662,040.91	8,949,854.36
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	31,257,859.10	36,141,281.77
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	462,765.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	8,152,321.00	1,859,818.18
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	28,412,421.63	19,045,693.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	872,730.00	1,120,207.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	872,730.00	1,120,207.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	34,394,824.55	42,928,951.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,583,937.98	31,785,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	3,810,886.56	11,143,151.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-33,522,094.55	-41,808,744.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		

3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Гадаад валютын ханшийн зөрүү	-6,827.80	23,611.74
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-5,116,500.72	-22,739,438.75
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	208,540,122.14	203,423,621.42
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	203,423,621.42	180,684,182.67

4.5 Аудит хийсэн зорилтот түвшингийн биелэлт

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
1	Кино уран бүтээл	бүлэг	32.00	32.00		100
	Түүхийн хүрд	бүлэг	12.00	12.00		100
	Баримтат кино	бүлэг	10.00	10.00		100
	Уран сайхны кино	бүлэг	10.00	10.00		100
2	Нийт орлого	мян.төг	360,000.00	348,225.80	11,774.20	97
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	248,000.00	248,225.80	-225.80	100
	Улсын төсвөөр гүйцэтгэсэн ажил	мян.төг	110,000.00	108,900.00	1,100.00	99
3	Нийт зардал	мян.төг	355,000.00	347,326.90	7,673.10	98
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	77,000.00	60,778.60	16,221.40	79
4	Нийт ашиг	мян.төг	5,000.00	922.50	4,077.50	18
5	Цэвэр ашиг	мян.төг	4,500.00	610.90	3,889.10	14
6	Төсвийн төлбөрт	мян.төг	76,900.00	84,955.50	-8,055.50	110
	НӨАТ-т	мян.төг	24,000.00	22,884.60	1,115.40	95
	НДШ-д	мян.төг	32,000.00	36,064.00	-4,064.00	113
	ААНОАТ-т	мян.төг	1,200.00	311.60	888.40	26
	ХХОАТ-т	мян.төг	16,700.00	13,830.00	2,870.00	83
	Бусад татвар хураамж	мян.төг	3,000.00	11,865.30	-8,865.30	396
7	Төрийн өмчийн ногдол	мян.төг				
8	Хөрөнгө оруулалт, их засвар	мян.төг	50,890.00	29,864.10	21,025.90	59
9	Нийт авлага	мян.төг	40,000.00	51,176.60	-11,176.60	128
10	Нийт өглөг	мян.төг	2,000.00	3,998.80	-1,998.80	200
11	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	0.99	1.00	-0.01	101
12	Ажиллагсдын тоо	хүн	25.00	23.00	2.00	92
13	Цалингийн сан	мян.төг	188,223.00	162,899.10	25,323.90	87
14	Дундаж цалин	мян.төг	627.40	590.20	37.20	94

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил

Огноо:	Аудитын нэр:	“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/66/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны нэр	
				Албан тушаал	Овог нэр
1	Төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлснээс олсон орлогын 30 хувийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлээгүй.	3.2	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Ж.Солонго Г.Төрбат
2	Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжгүй санхүүгийн тайланг эксел программ ашиглан бэлтгэж байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ж.Солонго Г.Төрбат
	Дүн	3.2			

